



МУБИС-ИЙН ОЮУТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААГ ШИНЖЛЭХ НЬ

Ч.Долгоржав, Б.Батчулуун
МУБИС-ийн МБУС-ийн Мэдээлэл зүйн тэнхимийн багш

Abstract: There are several types of assessment for quality of education in universities and a Student Satisfaction Survey (SSS) is one of them. In this study we analyzed the SSS of Mongolian National University of Education (MNUE) and compared this survey with the assessments of the quality of educational service in some other countries either. Surprisingly, the study shows that some words in the SSS questionnaire have ambiguous meaning and some questions are still uncertain to answer. Caused by such reasons (like not clear question), students give any negative answers. Negative survey result itself implicates unpleasant consequence for teacher's job position in MNUE. Since the SSS result is such an important thing for teacher, we concluded that there is inevitable need to re-design and improve this questionnaire. Our suggestion is to reconsider about what the main objective of survey is, how we evaluate the survey result, how to get the actual result and how this survey helps or supports teacher development.

Түлхүүр үг: оюутны сэтгэл ханамжийн судалгаа (ОСХС), МУБИС, үнэлгээ

Удиртгал

МУБИС-д оюутны сэтгэл ханамжийн судалгааг (ОСХС) сүүлийн 10-аад жил тасралтгүй авч байгаа бөгөөд жилд 2 удаа авч багшийн ажлын чанар, аттестатчиллын нэгэн үзүүлэлт болгон тооцохоор тусгажээ (МУБИС-ийн тайлан).

Мөн, МУБИС-ийн дотоод журам (Ректорын 2007 оны 230 тоот тушаал)-ын 7.2-т багшийн үйл ажиллагааны талаарх ОСХС-ны үнэлгээгээр хоёр удаа хангалттай үнэлгээг 60 хувиас дээш аваагүй тохиолдолд

хөдөлмөрийн сахилгын ноцтой зөрчилд тооцно хэмээн тусгасан байна (МУБИС-д мөрдөх дүрэм журмын эмхэтгэл).

Өөрөөр хэлбэл ОСХС-ны үр дүн нь багшийг үнэлэх, албан тушаалын өөрчлөлтөд нэгэн томоохон үзүүлэлт болоод байна. Нэгэнт, ОСХС-ны үр дүнд ихээхэн ач холбогдол өгч байгаа дээрх нөхцөлд, энэхүү ОСХС-ны зорилго, асуулгын стандарт, үнэлгээний аргачлал, үнэлүүлэгч багшийн хөгжилд нөлөөлж буй нөлөөлөл зэргийг тодорхой болгох шаардлага урган гарч байна. Дээрх шаардлагын үүднээс,

Нэгд олон улсын их дээд сургуулиудад ОСХС-г хэрхэн зохион байгуулдаг, түүний бодит зорилго, асуулгын стандарт, үнэлгээний аргачлал, үр нөлөөг судалж тойм танилцуулга хийнэ.

Хоёрт, МУБИС-ийн ОСХС-ны асуулгыг олон улсын түвшиний ОСХС-ны асуулгатай харьцуулалт хийж, асуудал дэвшүүлнэ.

Эцэст нь, ОСХС-нд гарч буй асуудлуудыг МУБИС-ийн оюутан суралцагчдаас авсан анкет судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, цаашид ОСХС-ыг сайжруулах саналыг дэвшүүлнэ.

I. Их дээд сургуулийн боловсролын үйлчилгээг оюутны сэтгэл ханамжаар үнэлэх нь

Факультетийн/тэнхимийн хөгжил (Faculty Development) болон багшийн хөгжил (Staff Development) нь тухайн сургуулийн боловсролын үйлчилгээний чанарт шууд нөлөөлдөг чухал хүчин зүйл юм. Тиймээс сургуулиуд өөрийн хөгжлийн байдлыг

төрөл бүрийн үнэлгээний хөтөлбөрүүдээр дамжуулан тодорхойлж, энэ нь цаашид сайжруулах хөшүүрэг болдог. Жишээ нь, Канадын их, дээд сургуулиудыг нийтэд нь стандарт үнэлгээ хийсний дүнд оюутнуудын хамгийн өндөр сэтгэл ханамж, судалгаа хийх нөхцөл боломж, багшийн хичээл заалт болон сургалтын чанар гэх мэт үзүүлэлтээр нь эрэмбэлэн жил бүр олон нийтэд мэдээлдэг байна. Энэ нь сургуулиудын хооронд бодит өрсөлдөөн бий болгоно гэж үздэг байна (John, 2013).”АНУ гэхэд 1950 онд оюутнууд сайн дураараа сургуулийнхаа боловсролын үйлчилгээг үнэлэх ажлыг эхлүүлсэн ба 1960 он гэхэд ихэнх их дээд сургуулиуд системтэйгээр зохион байгуулдаг болжээ” (Lion, 2013).

Орчин үед танхимын, онлайн болон холимог аль ч хэлбэрийн сургалт явуулдагас үл хамааран Их сургууль тухайлбал, АНУ-ын Бостоны ИС, Стэнфордын ИС, Рочестерийн ИС, Кийнийн ИС, Тринитийн ИС нь өөрийн үнэлгээг явуулдаг нийтлэг судалгаандаа ОСХС, багшийг үнэлэх судалгаа болон багшийн өөрийн сэтгэл ханамжийн судалгааг багтааж байна. Үүнд:

А. Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
Дээр дурдсан сургуулиудын туршлагаас харахад ОСХС гэдэг нь оюутны боловсрол авахад зориулж байгаа өртөг болон авч байгаа боловсролын чанарын хоорондын хамаарал, сургуулийн зүгээс өгч байгаа үйлчилгээнүүд (номын сан, эрүүл мэндийн төв, багшаас бусад ажилтнууд, сурах орчин, МТ-ийн асуудал г.м)-д өгөх ерөнхий сэтгэл ханамжийг илрүүлэхэд зориулагддаг нь харагдаж байна.

В. Багшийг үнэлэх судалгаа
Энэ судалгаа нь багшийн заах арга барил, хичээлийн агуулгад өгөх ерөнхий үнэлэмж бөгөөд бүх сургуулиуд үүнийг хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэх, багшийн ур чадварыг сайжруулах үндсэн зорилгоор авдаг бөгөөд багшийн хичээл заалт, үнэлгээ, академик дэмжлэг, зохион байгуулалт, хичээлийн зорилгод хэр нийцсэн сургалт явуулдаг болон зорилгодоо хүрдэг эсэх, сурах нөөц эх

сурвалж, оюутны хувийн хөгжил талаас нь илүү тодорхойлдог байна.

МУБИС-ийн ОСХС-г дээрх судалгаануудтай харьцуулбал нэршлийн хувьд А, агуулга болон зорилго нь В судалгаатай тодорхой хэмжээгээр давхцаж байна.


Япон улсын хувьд их дээд сургуулиудад боловсролын үйлчилгээндээ өөрийн үнэлгээ болон хяналт тавих нь заавал биелүүлэх үүрэг бөгөөд 2000 оны 11 дүгээр сард зохиогдсон ИС-уудын зөвлөлийн хуралдаанаар өөрийн үнэлгээний нэг хэлбэр бол “хичээлийн талаарх ОСХС” хэмээн тодорхойлон зааж өгчээ (Их сургуулийн хичээлийн үнэлгээний асуудал). 2011 онд нийт сургуулиудын 93% буюу нийт 708 сургууль (улсын, хувийн, орон нутгийн сургууль) дээрх судалгааг авсан дүн мэдээ байна (Боловсрол, Соёл Шинжлэх ухааны яам). Судалгааны асуулгад нийтлэг орсон агуулгыг харвал хичээл зааж буй багшийг нь бус хичээлийг нь объект болгон асуусан асуулга зонхилж байлаа. (1-р зураг. Японы их дээд сургуулиудын ОСХС-ны асуулгын нийтлэгагуулга) Өөрөөр хэлбэл Япон улсын их дээд сургуулиуд үйлчлүүлэгчдээ (оюутандаа) санал болгож буй хичээлийнхээ (хөтөлбөр, зорилго, цагийн багтаамж, агуулга, үнэлгээний арга гэх мэт) талаар сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулдаг байна.

Энэхүү судалгааг улирлын явцад 1-2 удаа авдаг ба үр дүн нь нэг өдрийн дараа багшид хүрдэг учир багш өөрийн үйл ажиллагааг сайжруулах нөхцөл болдог байна. Энэ нь тус судалгааны үр өгөөжийг нэмэгдүүлдэг ажээ. Мөн судалгааны үр дүнг бодитой байлгахын тухайн хичээлийн 80-аас дээш хувьд оролцсон оюутнаар үнэлүүлэх шаардлагатай талаар судлаачид дурдсан байна (2011 онд хичээлийн үнэлгээг хэрэгжүүлсэн улсын болон хувийн 709 сургууль).



Зураг 1

Японы их, дээд сургуулиудын ОСХС-ны асуулгын нийтлэг агуулга



II. МУБИС-ийн ОСХС-ны талаарх судалгаа, түүнд хийсэн анализ

МУБИС-ийн ОСХС-ны асуулгыг авч үзвэл, 6 асуулгын 5 нь багшийн талаар асуусан байгаа нь “Хичээлд хандаж буй багшийн дүр төрх”-г объект болгосон ОСХС гэж хэлж болохоор байна (1-р хүснэгт).

Хүснэгт 1

МУБИС-ийн ОСХС-ны асуулгын объект, үндэслэл

№	Асуулга	Багш объект хэмээх үндэслэл	Хичээл объект хэмээх үндэслэл
1	Багшийн заадаг хичээл оюутны хэрэгцээ, сонирхолд нийцдэг эсэх	Нэг хичээлийг нэгээс олон багш заах боломжтой үед, зөвхөн тухайн багш заасан тохиолдолд гэсэн утгатай болно	Сургуулиас оюутанд санал болгож буй тухайн хичээл нь
2	Багшийн харилцааны соёл, үлгэрлэл	Хичээлд сууж үзээгүй оюутан болон судалгаа, диплом удирдуулсан оюутнаас ч асуух боломжтой	-
3	Хичээлийн цаг ашиглалт / хичээлээс хоцрох, хугацааны өмнө завсарлуулах, хичээл таслах/	Багшийн хичээл дээрх цаг ашиглалт	-
4	Явцын болон улирлын шалгалтыг төлөвлөсөн хугацаандаа чанартай авч бодитой үнэлдэг эсэх	Багшийн үнэлгээний бодитой байдал	-
5	Багшийн оюутанд тусалдаг байдал	Хичээлд сууж үзээгүй оюутан болон судалгаа, диплом удирдуулсан оюутнаас ч асуух боломжтой	-
6	Хичээлийг заах ур чадвар	Багшийн заах ур чадвар	-

Хүснэгт 1-т үзүүлсэнчлэн 2 янзаар тайлбарлаж болох асуулгууд нь судалгааг бөглөгч оюутанд ч мөн салаа утгатайгаар ойлгогдох магадлал өндөр юм. Мөн асуулгын объект тодорхой бус байгаа нь оюутанд асуулгын утга бүрхэг санагдах, буруу ойлгогдоход хүргэж болно.

Хэрэв багшийг объект болгосон асуулгуудад оюутан хариулж байна гэж үзвэл, судалгааг оюутны нэр, код г.м ямар нэг тэмдэггүй авдаг, өөрөөр хэлбэл оюутан судалгаанд хариуцлагатай хандах нөхцөл бүрдүүлээгүй учир хувийн болон бусад харилцаанаас хамаарч багшид бодитой бус үнэлгээ өгдөг байж болох юм. Учир нь яг ийм шалтгааны улмаас судалгааг бодитой болгохын тулд оюутны нэртэй хамт авсан тохиолдол Японы Токио-Гакугэй ИС-д гарч байсан тухай тус сургуулийн профессор бидэнтэй ярилцсан юм.

Өмнө дурдсан таамаглалыг нотлохын тулд МУБИС-ийн бүрэлдэхүүний сургуулиудын 116 оюутнаас тус судалгааны асуулгын талаар анкет судалгааг авлаа. Судалгаанд хамрагдсан нийт оюутны 35% нь анх удаа өгч байгаа гэж хариулжээ.

Зорилго 1. МУБИС-ийн ОСХС-ны 6 асуултыг ойлгож хариулахад хүндрэл гарч байгаа эсэх. *СХС-ны дараах асуултуудад хариулахад хүндрэл гардаг эсэх.*

Бүрхээг: Асуулгын утга нь ойлгомжгүй

Эргэлзээтэй: Асуулга нь салаа буюу давхар утга илэрхийлсэн

Хариулах боломжгүй: Асуулгаа ойлгосон ч хариулт байхгүй

Харамсалтай нь асуулга бүрийн хувьд оновчтой бус гэсэн хариултын хувь харьцангуй өндөр байгаа нь судалгаанд хамрагдагч оюутнууд судалгааг бүрэн ойлголгүйгээр хариулж байгааг нотоллоо. Ялангуяа дараах 2 асуултад хариулахад нэлээн хүндрэл гардаг гэж дүгнэж байна.

Асуулга 1: МУБИС-ийн оюутан өөрөө хэрэгцээ, сонирхлоороо хичээл сонгодоггүй, сургуулиас төлөвлөсөн графикайн дагуу хичээл (ихэнхдээ) заагддаг.

Асуулга 5: “Багшийн оюутанд тусалдаг байдал” нь академик тусалцаа эсвэл хичээлээс бусад тусламж дэмжлэг гэдэг нь тодорхойгүй.

Хүснэгт 2

МУБИС-ийн ОСХС-ны асуулгад хариулахад гарах хүндрэл

№	Асуулга	Оновчтой %	Бусад (Оновчтой бус) %
1	Багшийн заадаг хичээл оюутны хэрэгцээ, сонирхолд нийцдэг эсэх	44	56
2	Багшийн харилцааны соёл, үлгэрлэл	64,3	35,7
3	Хичээлийн цаг ашиглалт /хичээлээс хоцрох, хугацааны өмнө завсарлуулах, хичээл таслах/	58,6	41,4
4	Явцын болон улирлын шалгалтыг төлөвлөсөн хугацаандаа чанартай авч бодитой үнэлдэг эсэх	62,6	37,4
5	Багшийн оюутанд тусалдаг байдал	45,7	54,3
6	Хичээлийг заах ур чадвар	69,6	30,4

Зорилго 2. Судалгааны хариуг зориудаар өөрчилсөн тохиолдол байгаа эсэх

Мөн л харамсалтай нь, бараг 3 оюутан тутмын нэг нь зориудаар бодит байдлаас өөрөөр (сөрөг) хариулсан тохиолдол байгаа нь харагдлаа. Зориудаар сөрөг үнэлгээ өгч байсан оюутнуудын дийлэнх нь багшийн оюутантай ялгавартай харьцдаг байдал, зааж буй хичээлээ халтуурддаг байдал болон багшийн зан араншин таалагддаггүй гэх мэт шалтгаанаас хамаарч тухайн багшид өгөх үнэлэмжийг зориуд сөрөг үнэлсэн гэж хариулсан байна.



ДҮГНЭЛТ, САНАЛ

Боловсролын үйлчилгээг чанартай үзүүлэх нь ямар ч их сургуулийн хувьд нэн тэргүүнд тавигдах асуудал бөгөөд үүнийг үнэлэх нэг хэлбэр нь ОСХС юм. Аливаа хэрэглэгч нь авч байгаа үйлчилгээндээ сэтгэл хангалуун байх нь олон хүчин зүйлээс хамаарна. МУБИС-ийн хувьд, ОСХС нь боловсролын үйлчилгээний чанарт бус зөвхөн багшийн үйл ажиллагаанд төвлөрдөг нь учир дутагдалтай байна. Иймд олон талт үнэлгээ хийх, гарсан үр дүн нь сургалтын үр дүнд эерэгээр нөлөөлдөг хүчин зүйл байлгах тал дээр цаашид анхаарах шаардлагатай гэж үзээд дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Олон төрлийн үнэлгээ хэрэглэх.
2. Хэрэв, цаашид багшийн үйл ажиллагаанд төвлөрсөн судалгаа авсаар байх бол нэрийг, өөрчлөх, асуултуудыг ойлгомжтой болгох, үнэлэгч болон үнэлүүлэгч талуудад судалгааны зорилго үр нөлөөг тодорхой болгох
3. Нэгээс олон хичээл заадаг багшийн хувьд гарсан судалгааны үр дүн нь аль хичээл дээр цаашид анхаарах шаардлагатайг нь тодорхой болгох

Олон улсын жишгээр багшийг үнэлэх судалгааны үр дүнг сайжруулахын тулд судалгаа нээлттэй, багшид хариу нь хурдан мэдэгддэг, үүний үндсэн дээр багш өөрийн үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийгээд заавал дараагийн хичээлийн жилийг хүлээх биш богино хугацаанд арга хэмжээ авах, засч сайжруулах боломж олддог байна. Иймд:

4. Судалгааны үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд багш үйл ажиллагаандаа судалгааны үр дүнг шууд тусгах боломжтой байх.
5. Оюутны ирц судалгааны үр дүнд нөлөөлж болохыг анхаарах. Жишээ нь, оюутан хичээлд оролцохгүй байх тусам тухайн хичээл ойлгомжгүй, сонирхолгүй болох нь илэрхий. Гэтэл хангалтгүй ирцтэй оюутнаар багшийг үнэлүүлж байгаа нь учир

дутагдалтай байж болно.

6. Оюутан судалгаанд зориудаар ташаа хариулт (эерэг, сөрөг) өгч байгаа асуудлыг анхаарах, судалгааны үр дүнд нөлөөлж байгаа эсэхийг авч үзэх.

Бид цаашид өмнө дурдсан багшийн сэтгэл ханамжийн судалгаа, ОСХС-ны талаарх багшийн сэтгэгдэл, ач холбогдлын талаар судалж үзнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын Боловсрол Их Сургууль. (2013). МУБИС-д мөрдөх дүрэм журмын эмхэтгэл. Улаанбаатар
- Glenn, Erickson., (2013). A Survey of Faculty Development Practices. University of Nebraska – Lincoln
- John, A. Centra. (2013). How Universities Evaluate Faculty Performance: A Survey of Department Heads
- Lion, F. Gardiner. (2013). Faculty Development in Higher Education, The National Academy
- Canadian University Report. Retrieved from <http://www.theglobeandmail.com/news/national/education/canadian-university-report/canadian-university-report-2013-student-satisfaction-survey-results/article4631980/>
- Faculty development for 21st century., (2009). EDUCAUSE REVIEW website. Retrieved from <http://www.educause.edu/ero/article/faculty-development-21st-century>
- What students want. Results of the Ontario Student Survey. (2010). OUSA Ontario Undergraduate Student Alliance website. Retrieved from <http://www.ousa.ca/2010/11/05/what-students-want-results-of-the-ontario-student-survey-by-sam-andrey-november-2010/>
- Monbukagakusho., (2012). 2011 Nendo Jyugyouhyouka wo jisshishita Kokukoushiritsu 708kou, (2011年度に授業評価を実施した国公私立708校. 文部科学省). Retrieved from <http://www.mext.go.jp>

Shakaikagakushano Zuisou., Daigakuni okeru
jyugyouhyoukano mondai., (2014). (社
会科学者の随想. 大学における授業評
価の問題). Retrieved from <http://blog.livedoor.jp/bbgmgt/archives/2782302.html>

МУБИС-ийн 2012-2013 оны хичээлийн
жилийн үйл ажиллагааны тайлан
цаашдын зорилт. *МУБИС-ийн вэб
сайт*. <http://www.msue.edu.mn/doc/tailanMUBIS1213.pdf>

